

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/13/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: Sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хэвчлэлээр авна уу.

ГАА-2024/230/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.22 № 57

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Шүүх шинжилгээний тухай хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс шинээр мөрдөж эхэлсэн бөгөөд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн нь Шүүх шинжилгээний ерөнхий газар болж, Шүүх шинжилгээний албыг хэлтэс болгон 5 аймаг дунд нэг бүсийн төвийг байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор Говь-Алтай аймгийн Мэргэжлийн хяналтын газрын /татан буугдсан/ хуучин барилгыг тус хэлтэс шилжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант оны гүйцэтгэлийн тайланг Шүүхийн шинжилгээний ерөнхий газарт хүргүүлсэн боловч дүгнээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0702900236

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотроод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,134.20	13,992.90
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	214,651.20	270,158.40
Нийт хөрөнгийн дүн	215,785.40	284,151.30
Нийт өр төлбөрийн дүн	215,785.40	284,151.30
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	215,785.40	284,151.30
Үйл ажиллагааны орлогын дүн	251,778.10	374,211.50
Үйл ажиллагааны зардлын дүн	290,846.80	305,845.40
Үйл ажиллагааны үр дүн	(39,068.70)	68,366.10
Үйл ажиллагааны бус үр дүн		
Үйл ажиллагааны нийт үр дүн	(39,068.70)	68,366.10
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		215,785.20
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	254,853.90	215,785.20
Тайлант оны үр дүн		
Эцсийн үлдэгдэл		
Мөнгөн гүйлгээний тайлан		(39,068.70)
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	215,785.20	284,151.30
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн		
Үйл ажиллагааны ЦМГ	205,261.20	320,555.40
Хөрөнгө оруулалтын ЦМГ	205,261.20	294,055.60
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	26,499.80
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	-
Урсгал зардал		
Хөрөнгийн зардал	311,673.00	311,673.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	311,673.00	311,673.00
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 26,499.8 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг аудитын явцад залруулав.

Залруулсан алдаа:

- **Хуультай холбоотой:** Амралт цалингийн завхардал, албан томилолтын зардал хоолны мөнгө илүү олгосныг 745.0 мянган төгрөгийг барагдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар

зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Мөнгөн гүйлгээний тайланд худалдаж авсан үндсэн хөрөнгө 26,499.8 мянган төгрөгийн зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар 1 заалт бүхий зөрчлийг арилгаж ажиллах зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогчлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн албаны цалингийн нэгдсэн систем Payroll.gov.mn программаас, цалин татагдахгүй эксэл хүснэгтээр хийсэн, амралт бодогдоогүй гараар тооцсон нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг: Цалин хөлсний бүртгэлийг хэрэглэж байгаа цалин, хөлсний бүртгэлийн мэдээллийг боловсруулахад эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программ хангамжийг ашиглана. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1-т Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн ашиглалт, бүртгэлийг сайжруулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

Говь-Алтай аймгийн Шүүхийн шинжилгээний хэлтсийн 2023 оны Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зааруулсан		Зааруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говь-Алтай аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	Мөнгөн гүйлгээний тайланд худалдаж авсан үндсэн хөрөнгө 26,499.8 мянган төгрөгийн зардлыг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй байна.	1	26,499.8	-	-	1	26,499.8	2	26,499.8	-	-	-	-
	Амралт цалингийн давхардал, албан томилолтын зардал хоолны мөнгө илүү олгосныг барагдуулсан.	1	745.0	-	-	1	745.0	1	745.0	-	-	-	-
Дүн		2	27,244.8	-	-	2	26,499.8	2	26,499.8	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Говь-Алтай аймгийн шүүх шинжилгээний хэлтэс	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем Payroll.gov.mn программаас, цалин татагдахгүй эксэл хүснэгтээр хийсэн, амралт бодогдоогүй гараар тооцсон байна.	1	-	0	-	0	-	-	1	-	-	-
Нийт		1	-	0	-	0	-	-	1	-	-	-